



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Цэнгэл сумын ТТЗ-ийн
2016 оны 12 дугаар сарын 31-нээр
дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын код: БӨА-2017/3/СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: 0

Тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 99417382 Цахим хаяг: mhkuangan@yahoo.com

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930, 99932710 Цахим хаяг: kh_jenisbek@yahoo.com

Аудитор: М.Айнур 94159291

Утас: Цахим хаяг:

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	8
2.9.1	Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9.2	Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9.3	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9.4	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	9
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.11	ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ, САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА	9
2.12	Шилэн дансны мэдээлэл	15
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	15
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	15
3	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	17
3.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	17
3.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	20
3.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	26
3.4	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	33

1 Аудитын гэрчилгээ



ЦЭНГЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Х.МЕЙРАМБЕК ТАНАА

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий сум, Баян-Өлгий аймаг,
Утас/факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2017.03.24 № 47 ТТЗ-БАНК/17-ТТЗ
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Цэнгэл сумын ТТЗ-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусвар болсон, аккрузал сууриар бэлтгэгдсэн, жилийн эцсийн нэгдсэн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1-д заасан бүрэн эрхийн дагуу УАГ-ын харьяа Баян-Өлгий аймгийн Аудитын газраас аудит хийв.

Цэнгэл сумын ТТЗ-ийн удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь Цэнгэл сумын ТТЗ-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Цэнгэл сумын ТТЗ-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтөлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

Зөрчилгүй санал дүгнэлт

Цэнгэл сумын ТТЗ-ийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.ХУАНГАН

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Цэнгэл сумын Засаг дарга Х.Мейрамбек танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.2 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Цэнгэл сумын Засаг даргын 2016 он оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Цэнгэл сумын Засаг даргын 2016 он оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 3 сарын 10-наас 2017 оны 3 сарын 15-ны хооронд хийж, аудитын тайланг 2017 оны 3 сарын 15-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Цэнгэл сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитыг Аймгийн аудитын газрын аудитор М.Айнур хариуцаж хэрэгжүүлэв.

Цэнгэл сумын Засаг даргын 2016 он оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2017 оны 3 дугаар сарын 05-нд төрийн аудитын байгууллагад 3 сарын 02-ны өдрийн 01/180–р албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Цэнгэл сумын Засаг дарга *“төрийн хууль хэрэгжүүлэх, ард иргэдэд үйлчлэх” эрхэм зорилгын дор* аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд дараах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Цэнгэл сумын Засаг дарга дээрх хуулиар тогтоосон чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд өөрийн эрхлэх асуудал, үйл ажиллагааныхаа чиглэл, цар хүрээг дараах байдлаар тодорхойлж баталгаажуулжээ. Үүнд:

Тайлант хугацаанд Цэнгэл сумын Засаг дарга *“төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, батлагдсан төсвийг үр дүнтэй хэмнэлттэй зарцуулах”* гэсэн зорилт дэвшүүлэн ажиллажээ.

Цэнгэл сумын Засаг даргын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Цэнгэл сумын Засаг даргын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт ороогүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Цэнгэл сумын Засаг даргын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Цэнгэл сумын Засаг дарга санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “Пластик”, “Аколоус” програм хангамж ашиглажээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Цэнгэл сумын Засаг даргын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 15 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 0 асуудал эрсдэл өндөр, 7 асуудал эрсдэл дунд, 0 асуудал эрсдэл бага гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 21 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 0 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь

үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг буюу 4273,0 сая төгрөгийг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Орон нутгийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан тул нийт орлогыг материаллаг байдлыг тооцох суурь үзүүлэлтээр сонгох нь тохиромжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

Цэнгэл сумын Засаг даргын 2016 он оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 4273,0 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь 85,5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь дотоод хяналтыг хэвийн гэж үзсэнтэй холбоотой юм. Чанартай холбоотой асуудал байхгүй байгаа болно.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 4 чиглэлээр 13 эрсдэлтэй асуудалд 13 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 62 хувь буюу 5 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой ОНХСангийн 17,1 сая төгрөгийн авлага, 14,4 сая төгрөгийн өглөг, бусад тайлагналтай холбоотой 46,7 сая төгрөгийн бүгд 78,2 сая төгрөгийн зөрчилтэй холбоотой асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Сая төгрөгөөр)				
№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	0	0	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн	0	0	

4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0
	Дүн	0	0.0

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Санхүүгийн тайланд нийтдээ 78,2 сая төгрөгийн алдаа зөрчил нь залруулагдсан байна. Зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдлаар дараах заалтад ангилан харуулав.

1. Эргэлтийн эмийн сангийн урьд оны гүйлгээг сумын нэгдсэн тайланд оруулалгүй ирүүлсэн. 2016 оны балансын эхний үлдэгдэлд эргэлтийн эмийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1.1 сая төгрөгийг оруулснаас эх үүсвэр талаас хуримтлагдсан үр дүнг тэр хэмжээгээр бууруулж, санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэлд өөрчлөлт орсон.
2. ОНХСангийн урьд оны санхүүжилтээс 15.6 сая төгрөгийг өөр дансанд байршуулж тайланд онд зарцуулсан, "Руханият" сургуулийн урьд оны нэмэлт санхүүжилтийн үлдэгдэл 0.3 сая төгрөгийг тайлант оны бусад орлогоор тайлагнасан.
3. ОНХСангийн 2016 оны батлагдсан төсөвт аймгийн ОНХСангийн төсвөөс дутуу олгосон 17.2 сая төгрөгийн орлогын шилжүүлэгийг санхүүгийн тайланд санхүүжилтийн авлагаар тусгаж харуулаагүй,
4. Мөн ОНХСангийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжсэн зарим төсөл арга хэмжээний дутуу олгогдсон 14.4 сая төгрөгийн ажлын гүйцэтгэлийн санхүүжилтийн өглөгийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж харуулаагүй орхигдуулж, Төсвийн тухай хуулийн 26.1 "Төсвийн байгууллага нь НББОУС болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузал суурьтай нягтлан бодох бүртгэл хөтлөнө" гэсэн заалтыг зөрчсөн.
5. Төсвийн гүйцэтгэлийн тайланг 29.5 сая төгрөгөөр илүү илэрхийлж, Сангийн сайдын 2012 оны 76 тоот тушаалаар баталсан Төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах журмыг зөрчсөн.

2.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал

Үгүй

2.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал

Үгүй

2.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Үгүй

2.9.4 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Үгүй

2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

ОНХС, СХСангийн авлага, өглөгийн бүртгэл тооцоо, баталгаажуулалт.

2.11 Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

1. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

/төгрөгөөр/

Данс ны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	22 470 943,22	19 994 061,22	2 476 882
311	Кассанд байгаа бэлэн мөнгө			
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	22 470 943,22	19 994 061,22	2 476 882
3121	Төгрөг	22 470 943,22	19 994 061,22	2 476 882
31211	Төрийн сангийн харилцах	21 357 107,22	18 824 617,22	2 532 490
31212	Монгол банкин дахь харилцах			0.00
31213	Арилжааны банк дахь харилцах	1 113 836	1 169 444	55 608

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар оны эцэст нийтдээ 19,9 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарчээ. Мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл нийт үлдэгдэл мөнгөний 1.2 сая төгрөг нь арилжааны банкин дахь, 18,8 сая төгрөг нь төрийн сан дахь харилцах дансны үлдэгдэл байна. Үүнд: ОНХСангийн үлдэгдэл 11,9 сая төгрөг, Сум хөгжүүлэх сангийн үлдэгдэл 0,5 сая төгрөг, Орон нутгийн орлогын данс үлдэгдэл 0,1 сая төгрөг, ЗДТГ-аас төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 6,3 сая төгрөг байна.

Арилжааны банкинд байгаа 1169,4 мянган төгрөг нь эргэлтийн эмийн сангийн үлдэгдэл байна.

2. Авлагын бүртгэл, тайлагнал

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
33	АВЛАГА	390 864 098	397 704 962	6 840 864
3351	Ажиллагчидтай холбогдсон авлага	788 707	602 550	-186 157

3352	Төлбөртэй үйлчилгээний авлага		1 774 875	1 774 875
	Татаас, санхүүжилтийн авлага		17 165 200	17 165 200
	Бусад авлага	390 075 391	378 162 337	-11 913 054
	Байгууллагаас авах авлага	4 971 647		-4 971 647
	Хувь хүмүүсээс авах авлага	385 103 744	378 162 337	-6 941 407

Санхүүгийн тайлан дахь авлагын үлдэгдэл өмнөх оноос 6,8 сая төгрөгөөр нэмэгдсэн дүнтэй байна. Санхүүгийн албанаас сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагын өмнөх оны үлдэгдлийг харилцагч бүрээр тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, залруулга хийсэнтэй холбоотой үлдэгдэл оны эхнээс 6,9 сая төгрөгөөр буурсан байна. Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагыг тооцоо нийлж, зээлдэгч нэг бүрээр гарын үсэг зуруулж үлдэгдлийг баталгаажуулаагүй байна. ОНХ Сангийн 2016 оны батлагдсан төсвөөс 17,2 сая төгрөгөөр санхүүжилтээ дутуу авсан боловч, санхүүгийн тайланд авлагаар харуулаагүй байсныг залруулав.

3. Бараа материалын бүртгэл, тайлагнал

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
35	БАРАА МАТЕРИАЛ	130690451,5	141291181,5	10600730
351	Түүхий эд материал	130690451,5	141291181,5	10600730
354	Хангамжийн материал			

Бараа материалын үлдэгдэл оны эхнээс 10,6 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд бичиг хэрэг, түлш шатах тослох материал, аж ахуйн материалын үлдэгдэл өнгөрсөн оноос буурсан дүнтэй байгаа бол хүнсний материал, бусад хангамжийн материалын үлдэгдэл урьд оноос өссөн дүнтэй байна. Тайлант онд нийтдээ 4,3 сая төгрөгийн материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

4. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9065019416,82	8798970583,72	-266048833,1
391	Газар			
392	Биет хөрөнгө	9064233983,73	8798594750,47	-265639233,26
393	Биет бус хөрөнгө	785433,09	375833,25	-409599,84

Үндсэн хөрөнгө оны эхнээс 266,0 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 5,4 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, 236,8 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авчээ. 21,0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж устгасан байна.

Тайлант онд үндсэн хөрөнгөнд 504,5 сая төгрөгийн элэгдэл тооцож, 17,4 сая төгрөгийн элэгдлийг хасах бичилт хийж, хуримтлагдсан элэгдлийн үлдэгдэл 3295,2 сая төгрөгт хүрсэн байна.

Төсөвт байгууллагууд нийтдээ 127,1 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авснаас ЗДТ Газар нь 133,8 сая төгрөгийн, Соёлын төв 100,0 сая төгрөгийн, Тыва бага сургууль 2,9 сая төгрөгийн хөрөнгийг хөрөнгө оруулалтаар хүлээн авсан байна. Тайлант онд нийтдээ

21,0 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хассаны 16,8 сая төгрөгийн хөрөнгийг акталж, 4,2 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хассан байна.

5. Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал

/төгрөгөөр/

4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	44,989,403.00	35,920,300.00	-9,069,103.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	44,989,403.00	35,920,300.00	-9,069,103.00
413	Өглөг	44,989,403.00	35,920,300.00	-9,069,103.00
	Ажилчидтай холбогдсон өглөг	102,954.00	177,288.00	(74,334.00)
	Бараа үйлчилгээний зардлын өглөг		14,386,800.00	(14,386,800.00)
4136	Бусад өглөг	44,886,449.00	21,356,212.00	23,530,237.00
	Байгууллагад төлөх өглөг	35,000,659.00	21,356,212.00	13,644,447.00
	Хувь хүмүүст төлөх өглөг	9,885,790.00		9,885,790.00

Оны эхэнд 44,9 сая төгрөгийн өглөгтэй байсан ба оны эцэст 35,9 сая төгрөг болж, 9,1 сая төгрөгөөр буурсан байна. Тыва бага сургууль нь 12,8 сая төгрөгийн, Соёлын төв нь 8,6 сая төгрөгийн, ОНХСангийн 14,4 сая төгрөгийн өглөгтэй байна.

6. Орлого, татаас санхүүжилтийн талаар

6.1 Улсын төсвийн санхүүжилт

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлангаар тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгээр нийтдээ 3347,5 сая төгрөгийн санхүүжилт, 79,2 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг хүлээн авсан байна.

6.2 Орон нутгийн төсвийн санхүүжилт

Орон нутгийн захиргааны байгууллагуудад аймгийн төсвөөс 347,2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг хүлээн авч, орон нутгийн татварын орлогоос 59,3 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн санхүүжүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтээр 66,8 сая төгрөг хүлээн авчээ.

6.3 Өөрийн орлого

Цэнгэл сумын төсөвт байгууллагуудад үндсэн үйл ажиллагааны орлогоос 1650,0 мянган төгрөгийн орлого оруулах төлөвлөгөө өгөгдсөнөөс 4573,2 мянган төгрөгийн орлого оруулсан байна.

6.4 Татварын орлого

Цэнгэл сумын ИТХ-аас сумын 2016 оны Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 67,2 сая төгрөгөөр баталжээ. Орлогын бүтцийг авч үзвэл нийт орлогын 58,2 хувийг ХАОАТатвараас, 33,4 хувийг бусад татвараас, 20,1 хувийг татварын бус орлогоос оруулахаар төлөвлөжээ.

Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

/төгрөг/

	ᠶᠡᠨᠨᠠᠭᠤᠨ ᠨᠠᠭᠤᠨ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	А.Урсгал орлого	67,185,000	59,296,015.0	-7,888,985	88,3
2	Татварын орлого	53,660,000	53,731,349	71,349	100,1
3	ХАОАТатвар	31,232,000.00	32,982,089.00	1,750,089.0	105.6
4	Өмчийн татвар	0.00	0.00	0.0	0.0

5	Бусад татвар	22,428,000.00	20,749,260.00	-1,678,740	92,5
6	II.Татварын бус орлого	13,500,000.0	5,564,666.0	-7,935,334.0	41.2
7	Б.ХӨРӨНГИЙН ОРЛОГО	25,000.0	0.0	-25,000.0	0.0

Гүйцэтгэлээр Орон нутгийн орлогод нийтдээ 59,3 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 7,9 сая төгрөгөөр буюу 11,7 хувиар тасарсан байна. Нийт орлогын 61,4 хувийг ХАОАТатварын, 35,0 хувийг бусад татварын, 9,4 хувийг татварын бус орлого бүрдүүлж байна.

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд ХАОАТатвар 1750,0 мянган төгрөгөөр буюу 105,6 хувиар давж, бусад татвар 1678,7 мянган төгрөг буюу 7,5 хувиар, татварын бус орлого 7935,3 мянган төгрөг буюу 58,8 хувиар, хөрөнгийн орлогын 100 хувиар тасарчээ.

Орон нутгийн орлогын 995 тоот дансанд оны эхэнд үлдэгдэл байгаагүй, тайлант онд 59,3 сая төгрөгийн татварын орлого оруулж, 59,2 сая төгрөгийг зарлагдаж, оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 0,1 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

6.5 Бусад

Тайланд онд ОНХСангийн санхүүжилтэнд 141,0 сая төгрөгийн санхүүжилт авч, Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс 18,9 сая төгрөгийг, Эргэлтийн эмийн санд 11,2 сая төгрөгийн, ЗДТГ-аас 6,3 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

7. Зарлага санхүүжилтийн талаар

7.1 Санхүүжилтийн зарцуулалт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Цэнгэл сумын ТТЗ-ийн өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой төсөвт байгууллагуудын хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2016 оны урсгал зардалд нийтдээ 3933,2 сая төгрөгийн төсөв батлагдсаны 3357,8 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, 431,2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 142,6 сая төгрөгийг ОНХСангийн хөрөнгөөр, 1,6 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээр 3347,5 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 420,6 сая төгрөгийн, аймгийн ОНХСангаас орлогын шилжүүлгээр 125,4 сая төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлогоос 4,6 сая төгрөгийн орлого оруулж, бүгд 3898,1 зарлага санхүүжилтээр ажиллаж, батлагдсан төсвөөс нийт дүнгээр 35,1 сая төгрөгөөр бага зарлага гаргажээ.

Энэ нь аймгийн ОНХСангаас 17,2 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон, ОНХСангаас 11,9 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулаагүй үлдэгдэл гарсан, төсөвт байгууллагуудаас 17,4 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна. Үүнд: Бүрэн дунд сургууль 7,9 сая төгрөгийг, Загастнуурын бага сургууль 37,7 мянган төгрөгийг, Тыва бага сургууль 0,7 сая төгрөгийг, 1-р хүүхдийн цэцэрлэг 63,3 мянган төгрөгийг, 2-р цэцэрлэг 787,9 мянган төгрөгийг, 3-р цэцэрлэг 1085,4 мянган төгрөгийг, Соёлын төв 458,3 мянган төгрөгийг, ЗДТГ 6,3 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	3933,2	3898,1	99,11%	35,1
1.1	Урсгал зардал	3933,2	3898,1	99,11%	35,1
1.2	Хөрөнгийн зардал	0	0	0.0%	0.0
2	Зардлыг сахуужүүлэх эх үүсвэр	3933,2	3898,1	99,11%	35,1
2.1	Улсын төсвөөс санхүүжих /Тусгай зориулалтын шилжүүлэг/	3357,8	3347,5	99,66%	10,3
2.2	Орон нутгийн төсвөөс	431,2	420,6	97,56%	10,5
2.3	Орон нутгийн хөгжлийн сангаас	142,5	124,4	87,96%	17,2
2.4	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос	1,6	4,6	277,16%	2,9

Төсвийн гүйцэтгэлийг зардлын зүйл ангиар авч үзвэл: Цалин хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ-ийн зардал, нормативт зардал, эд хогшил урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, урсгал шилжүүлгийн зардал, хөрөнгийн зардлыг 0,2-13,4 сая төгрөгөөр хэмнэж, байр ашиглалттай холбоотой зардал, хангамж бараа материалын зардал, томилолт зочны зардал, бараа үйлчилгээний бусад зардлуудыг 0,2-2,9 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан байна.

Үзүүлэлт	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,933,192,700.00	3,898,093,109.49	-35,099,590.51	99.11
УРСГАЛ ЗАРДАЛ	3,790,627,500.00	3,768,979,909.49	-21,647,590.51	99.43
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,568,927,000.00	3,552,563,839.49	-16,363,160.51	99.54
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,352,104,500.00	2,347,610,580.00	- 4,493,920.00	99.81
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	258,731,600.00	257,589,528.00	- 1,142,072.00	99.56
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	374,278,900.00	375,940,730.00	1,661,830.00	100.44
Хангамж, бараа материалын зардал	35,966,500.00	36,220,093.49	253,593.49	100.71
Нормативт зардал	390,368,600.00	387,333,434.00	-3,035,166.00	99.22
Эд хогшил, урсгал засварын зардал	11,077,200.00	11,038,710.00	- 38,490.00	99.65
Томилолт, зочны зардал	11,668,900.00	11,946,900.00	278,000.00	102.38
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	62,863,700.00	50,116,283.00	-12,747,417.00	79.72
Бараа үйлчилгээний бусад зардал	71,867,100.00	74,767,581.00	2,900,481.00	104.04
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	221,700,500.00	216,416,070.00	-5,284,430.00	97.62
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	142,565,200.00	129,113,200.00	-13,452,000.00	90.56
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,933,192,700.00	3,898,093,109.49	-35,099,590.51	99.11

Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	3,357,811,900.00	3,347,486,166.49	- 10,325,733.51	99.69
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	142,565,200.00	125,400,000.00	- 17,165,200.00	87.96
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	431,165,600.00	420,633,743.00	- 10,531,857.00	97.56
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,650,000.00	4,573,200.00	2,923,200.00	277.16

Төсвийн гүйцэтгэлийг байгууллага бүрээр харуулбал:

/төгрөг/

Төсөвт байгууллагуудын нэр	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувь
Сумын ИТХурал	51,063,500.00	51,041,200.00	-22,300	99.96
Сумын ЗДТГазар	380,102,100.00	369,592,543.00	-10,509,557	97.24
Бүрэн дунд сургууль	1,762,144,700.00	1,754,248,809.00	- 7,895,891	99.55
Загастнуурын бага сургууль	216,058,200.00	216,020,500.00	- 37,700	99.98
Тыва бага сургууль	415,895,600.00	415,895,600.00		100.00
Хүүхдийн 1-р цэцэрлэг	319,703,600.00	319,640,290.00	- 63,310	99.98
Хүүхдийн 2-р цэцэрлэг	215,169,400.00	214,384,258.49	- 785,142	99.64
Хүүхдийн 3-р цэцэрлэг	162,472,500.00	161,387,096.00	- 1,085,404	99.33
Руханият дунд сургууль	191,892,500.00	191,892,500.00		100.00
Соёлын төв	76,125,400.00	74,877,113.00	-1,248,287	98.36
ОНХСан	142,565,200.00	129,113,200.00	- 13,452,000	90.56
Бүгд	3,933,192,700.00	3,898,093,109.49	- 35,099,591	99.11

Төсөвт байгууллагуудаас Тыва бага сургууль, Руханият дунд сургууль батлагдсан төсвийг бүрэн зарцуулж, бусад төсөвт байгууллагуудын төсвийн зарлага төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан байна.

7.2 Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийтдээ 79,2 сая төгрөгийн орлого хүлээн авч урсгал зардалд 79,2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

7.3 Тусгай зориулалтын шилжүүлгийн зарцуулалт

Цэнгэл сумын 8 төсөвт байгууллага тусгай зориулалтын шилжүүлгээр 3933,2 сая төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөгдсөнөөс 3898,1 сая төгрөгийн санхүүжилтийг авч 11,1 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

7.4 Сангийн зарцуулалт

Цэнгэл сумын ОНХСан нь оны эхэнд мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй ба тайлант онд 141,0 сая төгрөгийн санхүүжилт авч, 129,1 сая төгрөгийг сумын ИТХурлаас батлагдсан төсөл арга хэмжээнд зарцуулж, оны эцэст 11,9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Сум хөгжүүлэх сангийн харилцах данс оны эхэнд 0,7 сая төгрөгийн үлдэгдэлтэй, тайлант онд эргэн төлөлтөөс 18,8 сая төгрөгийн орлогыг оруулсан ба тайлант онд 19,1 сая

төгрөгийг зээл олгож, оны эцэст 0,4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. СХСан нь жилийн эцэст 378,2 сая төгрөгийн зээлийн авлагатай байна.

Эргэлтийн эмийн сан оны эхэнд арилжааны банкин дахь харилцах дансандаа 1101,2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 11,2 сая төгрөгийн орлого оруулж, 11,2 сая төгрөгийг зарцуулж оны эцэст 1169,4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

8. Эзэмшигчийн өмчийн талаар

Цэнгэл сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар эзэмшигчийн өмч 242,0 сая төгрөгөөр буурч 9322,0 сая төгрөг болсон байна. Үүнээс ЗГОКапитал 1835,4 сая төгрөг, дахин үнэлгээний нэмэгдэл 1197,3 сая төгрөг, хуримтлагдсан үр дүн 6289,3 сая төгрөг байна.

Цэнгэл сумын сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар тайлант онд -242,0 сая төгрөгийн үр дүнтэй ажиллаж, хуримтлагдсан үр дүн 6289,3 сая төгрөг болж буурсан дүнтэй байна. Цэнгэл сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар дахин үнэлгээний нөөц 1197,3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Цэнгэл сумын ТТЗ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянав.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2016 он оны жилийн эцсийн байдлаар өмнөх оны зөвлөмжийн биелүүлж, биелэлтийг хугацаанд ирүүлсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг Цэнгэл сумын Засаг даргын 2016 оны 10 сарын 25-ны өдрийн 1-01/321 дугаар албан бичгээр манайд ирүүлсэн бөгөөд аудитын явцад шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр биелэлтийн талаарх мэдээллийг дахин нягталсан болно.

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Цэнгэл сумын Засаг даргын 2016 он оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Цэнгэл сумын Засаг даргын 2016 он оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

2.15 Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн талаар

Цэнгэл сумын бүх төсөвт байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дүгнэлтэд оруулсан.

Төсвийн шууд захирагчийн нэр	Алдаа, зөрчлийн дүн /мян. төг/	Аудитор ын санал дүгнэлт бүгд	Үүнээс			
			Зөрчил гүй санал дүгнэлт	Хязгаарлалттай санал дүгнэлт	Сөрөг санал дүгнэлт	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
Сумын ИТХурал		1	1			
Сумын ЗДТГазар		1	1			
Бүрэн дунд сургууль		1	1			
Загастнуурын бага сургууль	1041,4	1	1			
Тыва бага сургууль	1089,5	1	1			
Хүүхдийн 1-р цэцэрлэг		1	1			
Хүүхдийн 2-р цэцэрлэг		1	1			
Хүүхдийн 3-р цэцэрлэг		1	1			
Соёлын төв	839,1	1	1			
Сумын ТТЗ-ийн СНТайлан	78209,0	1	1			
Дүн	81179,0	10	10			

Цэнгэл сумын төсөвт байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийтдээ 81,1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, залруулга хийгдсэн байна. Загастнуурын бага сургуульд 1041,4 мянган төгрөгийн, Тыва бага сургуульд 1089,5 мянган төгрөгийн үдийн цайны зардлын гүйцэтгэлээс илүү олгосон санхүүжилтийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

3 Аудит хийсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**3.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	544,025,492.72	558,990,204.72
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	22,470,943.22	19,994,061.22
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
31110	Төгрөг		
31130	Нэмэлт санхүүжилт		
31140	Касс арилжааны банк		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	22,470,943.22	19,994,061.22
3121	Төгрөг	22,470,943.22	19,994,061.22
31211	Төрийн сангийн харилцах	21,357,107.22	18,824,617.22
31212	Монгол банкин дахь харилцах		
31213	Арилжааны банк дахь харилцах	1,113,836.00	1,169,444.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах		
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах		
31216	Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк		
33	АВЛАГА	390,864,098.00	397,704,962.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	788,707.00	602,550.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		1,774,875.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага		17,165,200.00
33400	Зээлийн хүүгийн авлага		
335	Бусад авлага	390,075,391.00	378,162,337.00
3351	Байгууллагаас авах авлага	4,971,647.00	
3352	Хувь хүмүүсээс авах авлага	385,103,744.00	378,162,337.00
35	БАРАА МАТЕРИАЛ	130,690,451.50	141,291,181.50
351	Түүхий эд материал	-	-
35110	Тусгай зориулалттай материал		
35130	Эм боох материал		
35200	Дуусаагүй үйлдвэрлэл		
35300	Бэлэн бүтээгдэхүүн		
354	Хангамжийн материал	128,940,451.50	139,541,181.50
35410	Бичиг хэргийн материал	550,800.00	324,800.00

Цэнгэл сумын ТТЗ-ийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

35420	Аж ахуйн материал	68,694,233.00	61,710,734.00
35430	Сэлбэг хэрэгсэл		
35440	Түлш, шатах тослох материал	9,598,400.50	7,199,089.50
35450	Барилгын засварын материал	103,700.00	
35460	Хүнсний материал	19,584,268.00	35,106,301.00
35470	Бусад хангамжийн материал	30,409,050.00	35,200,257.00
35500	Биологийн хөрөнгө		
35600	Мал амьтад	1,750,000.00	1,750,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	9,065,019,416.82	8,798,970,583.72
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,065,019,416.82	8,798,970,583.72
391	Газар		
392	Биет хөрөнгө	9,064,233,983.73	8,798,594,750.47
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,611,617,813.00	6,711,617,813.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2,262,690,610.05)	(2,383,135,497.25)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	171,697,300.00	182,147,300.00
